

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Монгол Улсад анх 2012 онд шүүхийн шинэчлэлийн багц хуулийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, эрх зүйн маргааныг шийдвэрлэх сонголттой хувилбарыг хөгжүүлэх зорилгоор эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг баталсан. Үүнээс хойш даруй 13 жил өнгөрсөн бөгөөд эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний хоёр ч судалгаагаар¹ шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа дүгнэлт гарсан бол шүүхийн бус хувийн /арилжааны эвлэрүүлэн зуучлал, төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлал гэж мөн нэрлэж байна/ эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн үндсийг хуульд тусгаж өгсөн боловч хангалттай хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүний учир шалтгаан нь хувийн эвлэрүүлэн зуучлах төвд хандаж эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээний үүрэг зөрчигдөхөд албадлага хэрэглэх боломжгүй, дахин шүүхэд хандах нөхцөл байдал үүсдэгтэй холбоотойгоор хувийн эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлдэггүй байна.

Түүнчлэн 2023 оны 12 дугаар сард хийгдсэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны тайлангийн дүгнэлт хэсэгт манай улс 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг батлахдаа Олон Улсын Арилжааны Эвлэрүүлэн Зуучлал болон Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хийгдсэн олон улсын эвлэрлийн гэрээний тухай загвар хуулиас² жишээ аван хуулийн төслийг бэлтгэсэн бөгөөд уг загвар хуулийн 14 дүгээр зүйлд хэрвээ талууд маргаанаа шийдвэрлэн эвлэрлийн гэрээ байгуулсан нөхцөлд тус эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй байж болно хэмээн заасан. Харин манай улсын хувьд төсөл бэлтгэхдээ уг зохицуулалтыг оруулалгүй орхигдуулсан нь өнөөгийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсны гол шалтгаан нөхцөл болж буй³ талаар судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

Дэлхийн бусад улс орнууд нь шүүхийн болон шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг зэрэг хөгжүүлэх байдлаар маргаан шийдвэрлэх сонголттой хувилбаруудыг иргэддээ санал болгож байх бөгөөд манай улсын хувьд шүүхийн бус хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжих орон зай, эрэлт байгаа нь харагдана. Тухайлбал, эвлэрүүлэн зуучлал өндөр хөгжсөн улс орнуудад шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг маргааны тоо болон эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлсэн хэрэг маргааны тоо тэнцүү буюу ойролцоо байдаг бол манай улсад энэ харьцаа ойролцоогоор 4:1 байгаа нь хувийн буюу арилжааны эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, нөөц, эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна.

¹ Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ нь 2015 болон 2020 онуудад хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

² НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн комиссын цахим хуудас (Сүүлд үзсэн: 2024.02.26) <https://shorturl.at/mnrR7>

³ М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он., 25 дахь тал.

Энэ ч үүднээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд хувийн эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, эвлэрүүлэн зуучлалд хандах хөшүүргийг бий болгох, хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулдаг болох, хувийн эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгаж өгсөн болно. Хуулийн төсөл нь 8 бүлэгтэй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т зааснаар хуулийн төсөл нь шинэчилсэн найруулга бол бүлэг тус бүрээр багцлан тайлбарыг тусгахаар заажээ. Хуулийг төслийг бүлэг тус бүрээр багцлан танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг илүү дэлгэрэнгүй байдлаар өөрчлөн найруулсан. Одоогийн хуулийн зорилт хэт ерөнхий байсан тул хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилготой уялдуулж найруулсан. Ингэснээр иргэд хуулийн зорилтыг уншаад эвлэрүүлэн зуучлалын ач холбогдлыг илүү ойлгох юм.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Зөрчлийн тухай хууль болон нэмж өгсөн бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 15.12 дугаар зүйлд “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол хүнийг 100 нэгжтэй, хуулийн этгээдийг 1000 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгоно” гэсэн заалт хүчин төгөлдөр үйлчилж байна.

Мөн зүйлд 2024 онд батлагдсан Шүүх байгуулах тухай хуулиар Гэр бүл, хүүхдийн дагнасан шүүхийг байгуулсан бөгөөд 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлнэ. Тус шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсруулж байгаа бөгөөд хэдийгээр батлагдаагүй буюу боловсруулах шатны төсөл боловч 2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс гэр бүл, хүүхдийн шүүхийн үйл ажиллагаа эхлэх хугацааг харгалзан хуулийн төсөл хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэмж тусгалаа.

Хуулийн төслийн 3.1 дэх хэсэгт Арилжааны эрх зүйн маргааныг нэмж өгсөн бөгөөд мөн 3.2-т Бусад хуульд тусгайлан заасан тохиолдолд буюу захиргааны эрх зүйн болон эрүүгийн эрх зүйн маргаан зэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болохоор тодорхой болгож өгсөн. Учир нь эрүүгийн эрх зүйн эвлэрүүлэн зуучлалд хэрэглэх зарчим нь арилжааны болон иргэний эвлэрүүлэн зуучлалд хэрэглэгдэх зарчмаас ялгаатай тул энэ хуулиар зохицуулах нь зохимжгүй билээ. Мөн төслийн 3.3-т эвлэрүүлэн зуучлалыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хэрэглэж болохоор илүү тодорхой болгож өгсөн. Төслийн 3.6-д Arb-Med хувилбараар явах боломжийг мөн нээж өгсөн. Шүүхэд иргэний хэрэг үүсгэсний дараа эвлэрүүлэн зуучлалд хандаж болдог шиг арбитрын хэрэг үүссэний дараа ч мөн эвлэрүүлэн зуучлалд хандаж, улмаар эвлэрсэн тохиолдолд арбитрын шийдвэрээр эвлэрлийг баталгаажуулдаг байх боломжийг нь нээлттэй болгож өгсөн.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Эвлэрүүлэн зуучлалын тодорхойлолтыг илүү тодорхой болгож Сингапурын конвенцод заасан тодорхойлолттой ойртуулж өгсөн. Төслийн 4.1.2-т “иргэн” гэсэн нэр томъёог хасаж, гадаадын иргэдийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас хасахгүйн тулд “хүн” гэсэн нэр томъёогоор сольсон. Төслийн 4.1.3-т эвлэрүүлэн зуучлагчийн тодорхойлолтод “бие даасан” гэх шинжийг нэмж өгсөн нь загвар хууль болон Сингапурын хуульд

тодорхойлолттой ойртуулж өгсөн. Төслийн 4.1.4-т хэсэгт шинээр “эвлэрүүлэн зуучлах төв”-ийн тодорхойлолтыг оруулж өгсөн бөгөөд хувийн эвлэрүүлэн зуучлал нь зөвхөн эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулан зуучлалын үйл ажиллагаа явуулах бөгөөд магадлан итгэмжлэгдсэн байх шаардлага төслөөр тавигдаж байгаа. Төслийн 4.1.6-д “Эвлэрүүлэн зуучлалыг ашиглах тухай гэрээ, хэлцэл”-ийг шинээр оруулж өгсөн бөгөөд хэрэв талууд гэрээндээ маргаан үүссэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалд хандах талаар тохиролцсон бол урьдчилан шийдвэрлэх ажиллагаа тогтоосон гэж үзэж, эвлэрүүлэн зуучлал хандах талаар илүү тодорхой болгох зорилготой болно. Мөн төслийн 4.1.7. “арилжааны маргаан”-ыг тодорхойлж өгсөн бөгөөд арилжааны маргаанд эвлэрүүлэн зуучлах эхний уулзалтыг заавал хийх үзэл баримтлалд нийцүүлэн Арилжааны хуулийн төсөлтэй уялдуулан нэр томъёоны тайлбарыг тусгалаа.

Хоёрдугаар бүлэг.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд “талуудын бие даасан байдал, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх тэгш байдлыг хангах”, “эвлэрүүлэн зуучлах ажиллагааны процессын ажиллагааг харилцан тохиролцох”, “эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хаалттай явагдах” зарчмуудыг нэмж тусгаж өгсөн. Эдгээр зарчмууд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлог шинж, шүүхтэй харьцуулахад давуу талууд байх бөгөөд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг илүү тодорхой болгохын тулд нэмж зарчмуудыг томъёолж өгсөн болно. Харин одоо хэрэгжиж байгаа хуульд байсан “талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих” зарчмыг хасаж өгсөн. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын сайн дурын үндсэн дээр явагдах нь боловч зарим төрлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр бус урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим хэрэгжих зохицуулалт орж ирсэнтэй холбоотой.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяаллын талаар, эвлэрүүлэн зуучлалаар маргааны шийдвэрлүүлэх хөшүүрэг болсон зохицуулалтуудыг нэмж тусгаж өгсөн болно. Төслийн 6.2-т шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв нь газар нутгийн харьяалал харгалзахгүйгээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаар тусгаж өгсөн нь иргэдэд илүү сонголттой хувилбарыг бий болгож өгнө. Төслийн 6.3-т хэрэв талууд иргэний хэрэг үүссэнээс хойш эвлэрүүлэн зуучлалд хандахаар тохиролцсон бол зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд биш шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд ч хандах боломжтой талаар илүү тодорхой зохицуулж өгсөн.

Төслийн 6.5-д “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, арилжааны маргаан, түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, хөршийн эрхийн маргаан, сууц өмчлөгчдийн холбооны маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэхээр тусгаж өгсөн. Эдгээр төрлийн маргааны сүүлийн 3 жилийн дунджийг авч үзвэл түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо 643, эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо 10, сууц өмчлөгчдийн холбооны хэргийг хянан шийдвэрлэсэн тоо 746 байна.

Түүнчлэн түрээсийн гэрээ болон эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой маргааны талууд бусад төрлийн маргааны талуудтай харьцуулахад эвлэрэх магадлал өндөр байдаг тул энэ шинжид нь тулгуурлан урьдчилан шийдвэрлэх журмыг тогтоож

өгсөн. Хуулийн төслийн 6.6 дахь хэсгийг өмнөх заалтаас өөрчлөн найруулсан бөгөөд талууд маргаан гарсан тохиолдолд эвлэрүүлэн зуучлалаар маргааны шийдвэрлүүлэх тохиролцоо хийсэн бол урьдчилан шийдвэрлэх ажиллагаа тогтоосон гэж үзэх ба гэрээндээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны процессын талаар тохиролцож болох талаар нэмж тусгасан. Төслийн 6.9-д Arb-Med хувилбараар явах боломжийг мөн нээж өгсөн. Шүүхэд иргэний хэрэг үүсгэсний дараа эвлэрүүлэн зуучлалд хандаж болдог шиг арбитрын хэрэг үүссэний дараа ч мөн эвлэрүүлэн зуучлалд хандаж, улмаар эвлэрсэн тохиолдолд арбитрын шийдвэрээр эвлэрлийг баталгаажуулдаг байх боломжийг нь нээлттэй болгож өгсөн.

Харин гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлуулах ажиллагааг зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч хэрэгжүүлэх бөгөөд гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаа талуудын эрх ашгаар хязгаарлагдахгүй бөгөөд хүүхдийн эрхийн асуудал хөндөгдөх онцгой нөхцөлийг харгалзан зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч уг ажиллагааг хийхээр тусгалаа.

Гуравдугаар бүлэг.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлагчид уучлагчид тавигдах шаардлагыг хэвээр нь хадгалсан бөгөөд харин уг шаардлага нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хамааралтай байдлаар өөрчлөн найруулсан. Хуулийн төслийн 8, 9 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн эрх хэмжээг зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хамааралтай байдлаар өөрчлөн найруулсан.

Дөрөвдүгээр бүлэг.Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал нь “Эвлэрүүлэн зуучлах төв”-өөр дамжин явагдах бөгөөд төв нь хуулийн этгээдийн эрхгүй аль нэг байгууллагын дэргэд, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байхаар өөрчилсөн. Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг зөвхөн төвөөр дамжуулж явуулах бөгөөд хувь эвлэрүүлэн зуучлагч дангаар эвлэрүүлэн зуучлал явуулахгүй.

Эвлэрүүлэн зуучлах төвийг Хууль зүйн сайд магадлан итгэмжлэх бөгөөд Хууль зүйн яамнаас байгуулагдсан Эвлэрүүлэн зуучлалын хороо сайдад санал хүргүүлнэ. Мөн шүүхийн бус Эвлэрүүлэн зуучлах төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрлийг Эвлэрүүлэн зуучлах хорооны саналыг үндэслэн сайд олгохоор тусгасан.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц зохион байгуулалт, бүрэн эрхийг шинээр тусгаж өгсөн бөгөөд Эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах, шүүхийн бус Эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох санал гаргах, бүртгэл хөтлөх, мөн Эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагаанд гаргасан гомдлыг шийдвэрлэх, Эвлэрүүлэн зуучлах төвд ажилласан эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээтэй байхаар тусгаж өгсөн. Түүнчлэн хувь эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн асуудал болон эвлэрүүлэн зуучлах төвд хандаж гаргасан гомдлын асуудлыг шийдвэрлэх процессын журмыг тусгаж өгсөн болно.

Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо нь дэлхийн бусад улс орнуудад өөр өөр эрх бүхий этгээдэд хадгалагдаж, зохион байгуулагдаж байна. Хуулийн төсөлд Хууль зүйн яамны харьяанд эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоог төвлөрүүлж байгаа нь нэг төрлийн загвар бөгөөд Турк, Итали зэрэг улсад эвлэрүүлэн зуучлалын зохицуулагч байгууллага нь хууль зүйн яамны харьяанд байдаг. Хууль зүйн яам нь эвлэрүүлэн зуучлалтай холбоотой бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах бөгөөд эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулж буй төвүүд болон хувь хүмүүсийг бүртгэх, магадлан итгэмжлэх, сургах, эвлэрүүлэн зуучлагчтай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авах зэрэг эрх хэмжээтэй байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлээр Эвлэрүүлэн зуучлах төвд тавигдах шаардлага болон магадлан итгэмжлүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, болон хувь эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрөл олгох процессын зохицуулалтыг тусгаж өгсөн. Эвлэрүүлэн зуучлах төвд тавигдах шаардлагын тухайд Япон улсын туршлагыг харгалзан үзэж, тавигдах шаардлагуудыг тодорхойлж өгсөн болно.

Тавдугаар бүлэг.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч

Хуулийн төслийн 14.1-т эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын хүрээг өргөжүүлж “талуудын зөвшөөрснөөр” эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй этгээдийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч болгох байдлаар өөрчилсөн. Хуулийн төслийн 14.3-т эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зайнаас /цахимаар болон утсаар холбогдох байдлаар/ явуулж болох зохицуулалтыг тусгаж, хуулийн этгээдийн хувьд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан биечлэн оролцох талаар тусгаж өгсөн. Мөн төслийн 14.4-т эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч байж болох “мэргэжилтэн”-ийг нэмж тусгаж өгсөн.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талуудын эрх үүргийг одоо хэрэгжиж буй хуулийн зохицуулалтад төдийлөн өөрчлөлт оруулалгүй авч тусгасан бөгөөд, 15.1.10-т “Эвлэрүүлэн зуучлагчийг сонгохтой холбоотойгоор эвлэрүүлэн зуучлах төвөөс туслалцаа хүсэх” эрх болон 15.2.3-т “...эвлэрүүлэн зуучлагчийг сонгоход түргэн шуурхай хандах” үүргийг нэмж тусгаж өгсөн. Учир талууд эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчаа түргэн шуурхай сонгож, процессыг түргэн шуурхай явуулах шаардлагатай тул дээрх эрх болон үүргийг төсөлд тусгаж өгсөн.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлд өмгөөлөгч эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох талаар ингэхдээ “үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэж байвал эвлэрүүлэн зуучлуулахыг зөвлөх, эрх ашигт нь нийцэж байвал үйлчлүүлэгчээ тохиролцоонд хүрэхийг зөвлөх үүрэгтэй” талаар тодотгож өгсөн. Энэ нь өмгөөлөгч талууд эвлэрэн хэлэлцэх гэж байхад өмгөөлөгч саад хийх нөхцөл байдлыг хаах зорилготой. Төслийн 18.1-т “талуудын хүсэлтээр” гуравдагч этгээд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох боломжтой болгон хуулийн зохицуулалтыг өөрчилсөн. Учир нь процессын журмыг талууд өөрсдөө шийдэх нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчим бөгөөд “эвлэрүүлэн зуучлагч”-ийн хүсэлтээр гуравдагч этгээд оролцох нөхцөлийг хааж өгсөн.

Зургадугаар бүлэг.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам

Хуулийн төслийн 20.1-т эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдоос бусад этгээдэд хаалттай явагдах талаар зохицуулж өгсөн. Учир нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлалыг оролцогч хэн боловч чанд хадгалах, задруулахгүй байх онцлогтой байдаг. Хуулийн төслийн 20.5-д “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын хүсэлтээр цахимаар явуулж болох” зохицуулалтыг тусгаж өгсөн. Үүнтэй холбоотойгоор цахимаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах зөвлөмж, журам боловсруулсан байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газар, хугацаа зэргийг тусгахдаа хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг өөрчлөхгүйгээр нэг зүйл болгож нэгтгэн боловсруулсан.

Харин эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болох зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75² дүгээр зүйлийн 75^{2.3}-т “Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.” гэж, 75^{2.4}-т “Энэ хуулийн 75^{2.3}-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэж тус тус заасан хугацаанд нийцүүлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 20 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг 20 хоногоор сунгаж болохоор тусгалаа.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлалын асуудлыг дэлгэрэнгүй тусгаж өгсөн. Ингэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид задруулж үл болох, гэрчээр оролцож үл болох баримт, мэдээллийг тодорхой зааж өгсөн. Түүнчлэн хуулийн төслийн 22.5-д эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчид ямар тохиолдолд мэдээлэл задруулж болох талаарх 5 нөхцөлийг төсөлд тусгаж өгсөн. Нууцлалтай холбоотой эдгээр заалт нь загвар хуулийн нууцлалын заалтуудыг үндэслэл болгосон.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэх, өргөдөл гаргах процессын журмыг тусгаж өгсөн. Төслийн 23.1-д эвлэрүүлэн зуучлах төвд хандаж өргөдөл гаргасныг уригдагч талаас эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох талаар хариу мэдэгдэл ирүүлснээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэхээр тусгаж өгсөн. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэзээ эхлэхийг тодорхой болгож өгснөөр хугацааг хэзээнээс эхэлж тоолох талаар тодорхой болж өгөх ач холбогдолтой.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагчийг сонгох процессын журмыг тусгаж өгсөн бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол нэг эвлэрүүлэн зуучлагч оролцоно. Уригдагч тал эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох талаар мэдэгдэл хүргүүлснээс хойш Эвлэрүүлэн зуучлах төв 7 хоногийн дотор талуудад эвлэрүүлэн зуучлагчдын танилцуулгыг талуудад хүргүүлж, талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг баталгаажуулах ажлын зохион байгуулсан байна. Ингэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй эвлэрүүлэн зуучлагчийг санал болгоно. Хэрэв 7 хоногийн дотор талууд эвлэрүүлэн зуучлагчаа сонгож чадаагүй бол Эвлэрүүлэн зуучлах төвөөс эвлэрүүлэн зуучлагчийг сонгож томилохоор тусгаж өгсөн. Энэ нь процессын түргэн шуурхай байдлыг хангах зорилготой.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтын талаар зохицуулсан. Ингэхдээ талууд эхний уулзалтаар эвлэрэлд хүрч болох бөгөөд хэрэв эхний уулзалтаар эвлэрэлд хүрээгүй бол дараагийн уулзалтын товд гарын үсэг зурах бөгөөд дараагийн уулзалтад ирүүлэх хөшүүргийг төслийн 26.4-дэх хэсэгт тусгаж өгсөн. Хэрэв талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох талаар мэдэгдэл хүргүүлсэн болон дараагийн уулзалтын товд гарын үсэг зурсан ч хүндэтгэн үзэх шалтгаанаар дараагийн уулзалтад ирээгүй улмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болж шүүхээр маргаан хянан шийдвэрлэгдэж байгаа бол тэмдэгтийн хураамжийг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уулзалтад ирээгүй талаар төлүүлэх хариуцлагын зохицуулалтыг оруулж өгсөн.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлд эвлэрлийн гэрээний зохицуулалтыг тусгахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтыг хэвээр хадгалж, харин эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах зохицуулалттай уялдуулан олон улсын зөвлөхийн саналыг үндэслэн 28.6-д Талууд эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлэх хугацааг харилцан тохиролцож гэрээнд тусгана. Эвлэрлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлэх хугацаа 20 хоног байхаар тусгалаа.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд шүүхийн бус буюу Эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээг талуудын аль нэг талын харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар тусгаж өгсөн.

Хуулийн төслийн 31.3-т эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлсийг тухайн эвлэрүүлэн зуучлах төвөөс тогтоосон журмаар зохицуулахаар тусгаж өгсөн.

Долдугаар бүлэг.Зарим төрлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Хуулийн төслийн 33 дугаар зүйлд Арилжааны хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх талаар тусгасан. Ингэхдээ хуулийн төслийн 33.1-т маргааны нэг тал нь арилжаа эрхлэгч байх тохиолдолд тухайн харилцаанаас үүссэн маргаанд эхний уулзалтыг эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар заавал хийх журмыг тусгаж өгсөн. Хэрэв эхний уулзалт амжилтгүй болсон дараагийн уулзалтыг талууд товлоогүй бол шүүхэд хандаж маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой.

Энэхүү загвар нь сайн дурын эвлэрүүлэн зуучлал болон эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар зайлшгүй ашигладаг загварыг хослуулсан шинжтэй, шүүхээр хянан шийдвэрлэгдэх маргаан болон эвлэрүүлэн зуучлалд хандсан маргааны тоог тэнцвэржүүлэх ач холбогдол бүхий загвар бөгөөд Энэ төрлийн арга механизмыг Чех, Итали зэрэг улс орнууд арилжааны болон иргэний эвлэрүүлэн зуучлалд ашигладаг бол, гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлалд Литва, Люксембург, Их Британи зэрэг улс орнууд эхний уулзалтыг заавал эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотой явуулсан байхыг шаарддаг байна.

Наймдугаар бүлэг.Бусад зүйл

Хуулийн төслийн 36.1-т “эвлэрүүлэн зуучлах төвүүд” нь мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, талуудыг эвлэрэхэд дэмжлэг үзүүлэг үүргийг мөн хүлээлгэж өгсөн.

Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүд

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйл буюу улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, хураамжаас чөлөөлөх зүйлд “58.5.Зохигчид шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлнө.” гэж нэмэхээр тусгасан. Энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг идэвхжүүлэх, эвлэрүүлэн зуучлалд хандах тоог нэмэгдүүлэх зорилготой зохицуулалт бөгөөд бусад улс орнуудад мөн хэрэглэгддэг идэвхжүүлэх хөшүүрэг юм.

Мөн хуулийн 59 дүгээр зүйл буюу улсын тэмдэгтийн хураамжийг буцаах зүйлд “59.7 Энэ хуулийн 74^{1.5}-т заасны дагуу талууд эвлэрсэн, эсхүл 74^{1.6}-т заасны дагуу зохигчид эвлэрсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.” гэж мөн нэмэхээр тусгасан бөгөөд иргэний хэрэг үүсгэхээс өмнө, иргэний хэрэг үүсгэснээс хойш аль ч шатанд талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн бол улсын тэмдэгтийн хураамжийг нь буцаан олгодог байхаар тусгасан. Одоо бол талууд эвлэрсэн бол 50 хувиар бууруулж тэмдэгтийн хураамжийг хуваарилж байгаа.

Энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг идэвхжүүлэх, эвлэрүүлэн зуучлалд хандах тоог нэмэгдүүлэх зорилготой зохицуулалт бөгөөд бусад улс орнуудад мөн хэрэглэгддэг идэвхжүүлэх хөшүүрэг юм.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7^{1.1} дэх хэсэгт заасны дагуу эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа зохицуулахаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргахад 30 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж төлдөг бөгөөд энэхүү хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал, инфляцтай уялдуулан 40 800 төгрөг болгож нэмэгдүүлсэн.

3.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.” гэж заасны дагуу боловсруулсан.